



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар: 2024/01


Улаанбаатар хот

Дотоод аудитын 2024 оны үйл ажиллагааны
төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.1, Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар баталсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дотоод аудитын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Дотоод аудитын хорооны үйл ажиллагааны зардлыг холбогдох зардлаас санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга /Н.Тавинбэх/-д үүрэг болгосугай.
3. Дотоод аудитын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, Дотоод аудитын хороонд танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Х.Бекболат/-т даалгасугай.

САЙД, ДОТООД АУДИТЫН
ХОРООНЫ ДАРГА



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Дотоод аудитын хорооны дарганы А.Сарын А.Едрийн
 2024/01 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

ДОТООД АУДИТЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Аудитын ажил	Аудитад хамрагдах нэгжийн нэр	Аудитын хамрах хугацаа	Аудитын сэдэв	Эрсдэлийн үнэлгээ	Хэрэгжүүлэх хугацаа	Аудитад зарцуулах хүн өдөр	Аудитын багийн гишүүд	
							ахлагч	902
АА 2024/01	Салбарын төрийн өмчит компани, үйлдвэрийн газар, төсөл хөтөлбөрүүд	2023 оны жилийн эцэс	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, цахим хуудас хөтлөлт	Дунд	2024.01.15-2024.02.05	16	ХШУДАГ-ын дарга	Шинжээч
АА 2024/02	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл	2022-2024 он	Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй, хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж 14 багц ажил	Их	2024.02.19-2024.03.19	20	ХШУДАГ-ын дарга	Ахлах, шинжээч, Шинжээч, Ахлах мэргэжилтэн
АА 2024/03	"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК	2023 он	"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засвар техник зохион байгуулалт, худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийх	Их	2024.03.25-2024.04.30	27	ХШУДАГ-ын дарга	Ахлах, шинжээч, Шинжээч, Ахлах мэргэжилтэн
АА 2024/04	"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК	2023-2024.01 улирал	"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засвар техник зохион байгуулалт, худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дотоод аудит хийх	Дунд	2024.05.06-2024.06.07	25	ХШУДАГ-ын дарга	Ахлах, шинжээч, Шинжээч, Ахлах мэргэжилтэн

AA 2024/05	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийх	2024.06.30	2024 оны эхний хагас жилийн байдлаар Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавих	Дунд	2024.08.19- 2024.09.06	15	ХШУДАГ-ын дарга	Шинжээч, Ахлах мэргэжилтэн
AA 2024/06	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл	2022-2024 он	Сайдын багцад тусгагдсан "Ховдын дулааны станцын өргөтгөл" төсөл арга хэмжээний хэрэгжилтэд дотоод аудит хийх	Дунд	2024.09.09- 2024.10.04	20	ХШУДАГ-ын дарга	Ахлах, шинжээч, Шинжээч, Ахлах мэргэжилтэн
AA 2024/07	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	2023-2024 оны 3 улирал	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засвар техник зохион байгуулалт, худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дотоод аудит хийх	Их	2024.10.07- 2024.11.08	25	ХШУДАГ-ын дарга	Ахлах, шинжээч, Шинжээч, Ахлах мэргэжилтэн
AA 2024/08	Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл	2019-2024 он	Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг нэмэгдүүлэх төслийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Их	2024.11.13- 2024.12.13	22	ХШУДАГ-ын дарга	Ахлах, шинжээч, Шинжээч, Ахлах мэргэжилтэн
AA 2024/09	Төлөвлөгөөт аудит болон Бусад нэмэлт ажлууд	-	Удирдлагын шийдвэрээр	-	Тухай бүр	59	ХШУДАГ-ын дарга	Шинжээч, Ахлах мэргэжилтэн
Нийт хүн өдөр						229 өдөр		

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР